

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	16
4.3	Аудит хийсэн санхүүгийн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	23
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Л.НАСАНЦЭНГЭЛ ТАНАА

2019.02.25 № 06/262
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Төсвийг үр ашиггүй төлөвлөж зарцуулсан, цалингийн санг зориулалт бусаар зарцуулсан, хүнсний материалыг норм нормативын дагуу зарцуулаагүй, өр авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг 184,123.7 мянган төгрөгийн зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Л.Насанцэнгэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 25-аас 2019 оны 2 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК-ийн захирал Ч.Мөнхтуяа, чанарын хяналтын менежер А.Оюун, аудитор Э.Цэвээнсүрэн, туслах аудитор А.Наранчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 5/101 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь “Монголын нийт хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг чанартай тэгш хүртээмжтэй үзүүлэн, анхан болон үндсэн мэргэжлийн тусламжийг мэргэжил арга зүйгээр хангахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Монгол Улсын Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2006 оны 331 тоот тушаалаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан болон хоёр дахь шатлалын тусламжийг мэргэжил арга зүйгээр хангах;
- Сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, нөхөн сэргээх;
- Гурав дахь шатлалын тусламж үйлчилгээг чанартай тэгш хүртээмжтэй хүргэх;
- Архидан согтуурах, мансуурах, тоглоомд донтох, стресст өртөх зэрэг сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх нийгэм орчны сөрөг хүчин зүйлсээс сэргийлэх;
- Эрдэм шинжилгээ статистик, тандалт судалгаа, мэдээллийн сүлжээ, гадаад харилцааг хөгжүүлэх;

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлага нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа 2017 онд гарсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous”, цалин хөлсний “Payroll” програм хангамж ашигладаг байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан 14 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь байгууллагын хөрөнгийн үнэлгээ, балансын данс зардлын дансдад алдаа гарсантай холбоотой юм.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны *нийт* зардал 11,458,063.8 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 114,580.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшинг дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 15 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн. 11 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож үүнээс 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөг/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	56,097.3	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	22,646.9	
3	Албан шаардлага өгсөн	4	97,097.1	
	Дүн	9	175,841.3	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Бичиг хэрэг, тээвэр шатахуун, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнс, урсгал засвар, багаж техник хэрэгсэл, мэдээлэл, технологийн зардлын ангиллаас бараа материал худалдан авахдаа холбогдох данс бүртгэлд тусгаагүй шууд зардлаар тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны "Төсөв байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 3.10.а дахь "Хүлээн зөвшөөрөх болон үнэлэх шалгуур нөхцлийг хангасан, тайлангийн хугацаанд хамаарах бараа үйлчилгээний зардлуудыг дараах байдлаар бүртгэнэ. (а) Тухайлбал, тайлангийн хугацаанд гарсан сургалт семинарын зардлыг; Дт.Зардал - Бараа үйлчилгээний зардал (Дэд ангиллаар) Кт. Мөнгөн хөрөнгө эсвэл Өглөг (Дэд ангиллаар)" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2.8.1.2 Төлбөртэй үйлчилгээний орлого болох 3,320.0 мянган төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдлийг Санхүүгийн тайланд тусгаагүй нь Сангийн сайдын 2012 оны "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6. "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кассдаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" заалтыг хэрэгжүүлээгүй, НББТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар энэ хуулийн" 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" санхүүгийн тайлангийн "үнэлгээ" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2.8.1.3 Барилгын засварыг капиталжуулан бүртгэлгүйгээр дахин үнэлгээ хийгдсэнээс санхүүгийн байдлын тайлан засагдсан нь Сангийн сайдын 2018 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 207 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал"-ийн 1.5 дахь заалт "Хөрөнгийн дахин үнэлгээний үр дүнг бүртгэл, санхүүгийн тайланд тусгахдаа НББОУС 16 "Үндсэн хөрөнгө", УСНБББОУС "Үндсэн хөрөнгө" УСНББОУС 21 "Хөрөнгийн үнэ цэнийн бууралт", НББОУС 36 "Хөрөнгийн үнэ цэнийн бууралт", УСНББОУС 31 "Биет бус хөрөнгө", НББОУС 38 "Биет бус хөрөнгө", СТОУС 13 "Бодит үнэ цэнийн хэмжилт" энэ аргачлал болон бусад холбогдох стандарт, журам, зааврыг баримтална" гэсэн заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: НББТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар

залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2.8.1.4 Эрүүл мэндийг дэмжих сангаас олгогдсон 2019 оны 2 дугаар улиралд хэрэгжих "Сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөрийн төслийн 10,920.0 мянган төгрөгийг 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдөр гадаад харилцааны асуудал хариуцсан эмч Елинагийн хувийн дансанд шилжүүлж авлага үүсгэсэн нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

2.8.1.5 Цалингийн сангийн зардлаас зориулалт бусаар хүн нас барах, өвдөх, гэр бүл болж тусдаа гарах, алтан гадас одонгоор шагнагдах, байгууллагын тэмцээнд түрүүлэх, шилдэг хамт олон ажилчдыг шагнах, гадаадруу томилолтоор явах гэх 56,497.4 мянган төгрөгийг үндсэн цалин дээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын 5/ “төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;” заалтыг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

2.8.1.6 Хоолны мөнгийг ажлын өдөрт 3700 төгрөгөөр тооцож олгох байсаныг ажлын өдрүүдийг харгалзалгүй тогтмол 81,400 төгрөгөөр бодож 455 ажилчид 15,699.7 мянган төгрөгийн хоолны мөнгө илүү олгосон нь Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлагын зөвлөл, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээний 3.20 дахь хэсэгт "...Хоолны мөнгө хоногт 3700 төгрөг, унааны зардал өдөрт 2500 төгрөг" байна гэсэн заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

2.8.1.7 2018 оны 10 дугаар сараас 12 дугаар сард аж ахуй нэгж байгууллагад 79,470.0 мянган төгрөгийг шилжүүлж авлага үүсгэснээс 13,980.0 мянган төгрөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” 20.2.6. “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

2.8.1.8 Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2004 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 77 дугаар тушаалаар батлагдсан хортой нөхцөлд тооцогдох ажлын байранд багтаагүй конторын 54 ажилчдад /дарга, санхүүгийн алба хаагч, компьютерийн инженер техникийн албан тушаалтан, мэргэжилтэн/ 12,734.4 мянган төгрөгийг олгосон нь Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2004 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 77 дугаар тушаал, Төсвийн тухай хуулийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох эздээр нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

2.8.1.9 Нэр бүхий 45 ажилчдын цалинг 1-21 хоногоор 9,912.5 мянган төгрөгийн цалин, ээлжийн амралтын олговрыг давхардуулж олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д “Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ” гэсэн заалт, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166-р тушаалаар баталсан “Ээлжийн амралт олгох заавар” 2-д “Ажил олгогч нь бүх ажилтныг ажлын жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлэх бололцоогоор хангаж, эдлүүлнэ”, 13-д “Ажил олгогч нь ажилтанг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох эздээр нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эрүүл мэндийг дэмжих сангаас олгосон санхүүжилтийн дагуу хийж гүйцэтгэж буй хөтөлбөрийг хэрэгжилт, түүний зардлыг хянах, байгууллагын бүтэц орон тоо, төсвийн төлөвлөлтөд анхаарал хандуулах чухал гэж үзсэн.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 9 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд улсын төсвөөс санхүүжих 9,235,790.9 мянган төгрөг, Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 441,000.0 мянган төгрөг нийт 9,676,790.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 9,665,591.2 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь 2018 онд хэвтэн эмчлүүлэгсэдийн орны эргэлт ихэссэн нь үндсэн үйл ажиллагааны орлогыг 49,4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зардлыг 7,0 сая төгрөгөөр, даатгал, тээврийн хэрэгслийн оношилгооны зардлаас 1,3 сая төгрөгийн хэмнэлт гарснаас шалтгаалжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn/Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2018 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг 138 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 2 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар хугацаанд нь хэрэгжүүлж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Байгууллагын даргын баталсан орон тоонд байхгүй зөвлөх гэсэн албан тушаалаар 7 хүнийг 61,083.9 мянган төгрөгөөр, гэрээтээр 12 хүнийг 27,903.8 мянган төгрөгөөр цалинжуулсан. Энэ нь (ОБ, ТБ, ИБ, ҮЗБ) гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2003 оны 233 дугаар "Төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхэд баримтлах чиглэл" тогтоолын 3.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Цалин хөлсийг холбогдох журам, зааврын дагуу олгоогүй байх, Төсвийн тухай хууль зөрчих, батлагдсан төсөв хэтрэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, цалингийн сангийн зардлыг зориулалтаар зарцуулах, гэрээт ажилтан, зөвлөхийн цалингийн санг төсөвт суулгаж ажиллах талаар зөвлөмж өгөв.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 5/143 Тоот албан бичгээр Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/74 "Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм ,эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай" тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу 1 хүнд өдөрт 190 грамм мах олгох нормтой бөгөөд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн даргын 2017 оны 05 дугаар сарын А/52 дугаар "Эмчлүүлэгчийн хүнсний бүтээгдэхүүний зохист хэмжээг батлах тухай"тушаалын 5 дахь хэсэгт 190 грамм мах дээр ясны хорогдол 30 хувь нэмж 247 грамм махаар тооцсон боловч өдөр бүр 270 грамм махаар тооцож олгосон нь махын зардлын 33,575.7 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарлагдсан байна. Энэ нь (Ү, ОБ) гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэндийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/74 "Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм ,эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай" тушаалын 4 дүгээр хавсралт СЭМҮТ-ийн даргын 2017 оны 05 дугаар сарын А/52 дугаар "Эмчлүүлэгчийн хүнсний бүтээгдэхүүний зохист хэмжээг батлах тухай"тушаал тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Хоолны зардлыг бараа материалын тайлантай тулган баримтжуулах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, Эрүүл мэндийн сайдын тушаал, байгууллагын гаргасан тушаалыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөв.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 5/143 Тоот албан бичгээр Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн

3.3 Зардлын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

1-12 дугаар сарын тээвэр шатахууны зарлагыг жолоочийн замын хуудас болон шатахуун авсан баримттай тулган шалгахад шатахуун авсан баримт байхгүй 22,521.6 мянган төгрөгийн шатахуун зарцуулагдсан байна. Энэ нь (ИББ, ОБ, ТБ) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Шатахууны зардал дансны анхан шатны баримтийн хөтлөлт дутуу

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, жолоочийн замын хуудасны тооцоог цаг хугацаанд нь хийж ажиллах талаар зөвлөмж өгөв

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

